



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/199

Номгон

Баталгаажсан үүлдэр, омгийн малд шилэн
сонголт ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 34 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, малын үндэсний бүртгэл мэдээллийн санд хамруулсугай.


2.Үзлэг ангилалт хийн баталгаажуулж ялган тэмдэглэн, бүртгэлжүүлэх малын тоо, төсвийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх ажилд шаардагдах 19,0 сая (Арван есөн сая) төгрөгийг жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн 2024 оны 11 дүгээр сарын 01-ний дотор тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

324310433

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дугаар сарын 27
 -ны өдрийн 01199 дүгээр захирамжийн хавсралт



**БАТАЛГААЖСАН ҮҮЛДЭР ОМГИЙН МАЛД ҮЗЛЭГ
 АНГИЛАЛТ ХИЙХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Сумын нэр	Малын төрөл	Үзлэг ангилалтад хамрагдах малын тоо	ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А/68-р тушаалын I хавсралтаар баталсан жишиг үнэ	Зардлын дүн /төг/
1	Баянбулаг	хонь	2000	1500	3,000,000
2	Баянхонгор	сарлаг	100	2500	250,000
3	Баянцагаан	хонь	1000	1500	1,500,000
4	Баян-Овоо	сарлаг	300	2500	750,000
5	Баян-Өндөр	ямаа	1000	1500	1,500,000
6	Бөмбөгөр	ямаа	1000	1500	1,500,000
7	Бууцагаан	ямаа	1000	1500	1,500,000
8	Галуут	сарлаг	300	2500	750,000
9	Жаргалант	хонь	500	1500	750,000
10	Жинст	тэмээ	150	2500	375,000
11	Гурванбулаг	хонь	834	1500	1,250,000
12	Хүрээмарал	хонь	500	1500	750,000
13	Өлзийт	сарлаг	300	2500	750,000
14	Эрдэнэцогт	сарлаг	500	2500	1,250,000
15	Баянлиг	тэмээ	500	2500	1,250,000
16	Богд	тэмээ	150	2500	375,000
17	Шинэжинст	ямаа	1000	1500	1,500,000
Бүгд			11134		19,000,000
1	Малын төрлөөр	Тэмээ	800	2500	2,000,000
2		Сарлаг	1500	2500	3,750,000
3		Хонь	4834	1500	7,250,000
4		Ямаа	4000	1500	6,000,000

.....оОо.....

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Залуучуудын Хөгжлийн Корпусны 2-дугаар сарын 27-ны өдрийн 195-дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



УДИРДАМЖ

Баянхонгор аймгийн "Youth power 2024"
байгальд ээлтэй залуусын чуулган зохион
байгуулах тухай

Нэг. Нийтлэг үндэслэл

Баянхонгор аймгийн хүүхэд, залуусын төлөөлөлд байгаль орчин, өв соёл, уламжлал болон тогтвортой хөгжлийн мэдлэг, мэдээлэл солилцох, шийдвэр гаргах үйл явцыг хүүхэд, залууст танилцуулах тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, аливаа шийдвэр тогтоолуудад хэрхэн байгальд ээлтэй зүйл заалтыг оруулж байгааг хэлэлцэж, орон нутгийн удирдлагуудад хүргэх

Хоёр. Зорилго

Өсвөр насны хүүхэд, залууст байгаль орчин, тогтвортой хөгжлийн мэдлэг олгож, хувь хүний хөгжил, ур чадварыг нь дэмжих замаар нийгэмд оролцоотой, хариуцлагатай, байгальд ээлтэй ухамсартай иргэн бэлтгэх.

Гурав. Зорилт

1. Баянхонгор аймгийн сурагчдын төлөөллүүдэд байгаль орчин, тогтвортой хөгжлийн мэдлэг, мэдээлэл олгох

2. Ардчилсан засаглалын зарчим ба олон улс хооронд төдийгүй тусгаар тогтносон улс орны түвшинд, эсвэл байгууллага ба тодорхой нийгмийн бүлгүүдийн доторх шийдвэр гаргах явц хэрхэн явагддагийг таниулан ойлгуулах

3. Бүх түвшний шийдвэр гаргах явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн оролцоотойгоор аливаа шийдвэр, тогтоолуудыг байгальд ээлтэй байх шаардлагыг хангахад хувь нэмэр оруулах

Дөрөв. Зохион байгуулагч:

1. Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Залуучуудын хөгжлийн төв

2. Монгол Экологи Төв

3. "Youth Sustainability Corps-Залуучуудын Тогтвортой Хөгжлийн Корпус"

Хөтөлбөр

2.

4."Тeen хуралдай 2022-2023" Байгальд ээлтэй залуусын чуулганы Баянхонгор аймгийн оролцогчид:

Тав. Дэмжигч байгууллага:

- 1.Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
- 2.Байгаль орчин, аялал жуулчлалын газар
- 3.Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар

Зургаа. Хамрах хүрээ:

-Баянхонгор аймгийн ЕБС-ийн 9-12 ангийн сурагч, Политехник коллежийн оюутнуудаас шалгаруулалтад тэнцсэн оролцогчдыг сумдын байгаль орчны хамгаалагч нар хариуцан оролцоно.

Долоо. Зохион байгуулах газар, хугацаа

- "Мазаалай" ресторан

- 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 08:00 цагт эхэлнэ.

Найм. Хүлээгдэж буй үр дүн:

1.Оролцогч хүүхдүүд байгаль орчинд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэх замаар тунхаг бичгийг батална.

2.Байгаль орчноо хамгаалахад дагаж мөрдөх тунхаг бичигтэй болно.

3.Багаар ажиллах чадварт

4.Дэлхий дахинд болон Монгол улсад тулгамдаж буй байгаль орчны асуудлуудыг тодорхойлно .

5."Их хуралдай"-н засаглалын ажиллах зарчим болон шийдвэр гаргах үйл явцыг таньж мэднэ.

6.Үе тэнгийн найз нөхдөдөө зөв үлгэр дуурайлал болох ба илүү олон шинэ зүйлийг танин мэдэх болно

Ес. Оролцогчдын сонгон шалгаруулалт:

Цахимаар авах үндсэн асуулт болон эсээ, видео бичлэг бүхий анкетын хариунаас үндэслэн аймаг сумдаас нийт 90 оролцогчийг зохион байгуулагчдын зүгээс шалгаруулна.

Жич: Шалгаруулалт 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн хийгдэж байгаа бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 23:00 цагт хаагдана.

Шалгаруулалтад оролцох цахим линк: <https://forms.gle/gytabDMbKwybtMq99>

Арав. Чуулганы үе шат:

Оролцогчдын сонгон шалгаруулалтын өргөдөл нээгдэх: 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 27-ны өдрийн хооронд

2.Оролцогчдын сонгон шалгаруулалтын хариу гарах хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр тэнцсэн оролцогчид руу холбогдоно.

Арван нэг. Сургуулийн нийгмийн ажилтан, оролцогч хүүхдүүдийн анхааралд:

-Оролцогч хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдаас бичгээр зөвшөөрөл авч ирэх

-Чуулганд оролцогч хүүхэд хувийн бэлтгэлээ сайн хангах (цаг агаарт тохирсон хувцас зэргийг бэлдэх)

- Өөрийн эрүүл мэнд болон харшилдаг хоол хүнсний талаарх мэдээллийг зохион байгуулах ажлын хэсэгт мэдэгдсэн байна.

-Чуулганд оролцогч хүүхдүүдийг хариуцаж ирэх албан хаагч нь орон нутгаас ирэх, буцах, Баянхонгор сумд байх хугацаанд хүүхдүүдийн аюулгүй байдалд бүрэн хяналт тавих.

- Чуулганд оролцох хүүхдүүдийг 18 цагаас хойш тээвэрлэхгүй байх, хурд хэтрүүлэхгүй байхыг хатуу анхаарах.

-Чуулганд оролцох хүүхэд, төлөөлөгчид 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 18:00 цагт Баянхонгор сумд ирсэн байх.

-Хүүхдийг тээвэрлэхдээ аюулгүй байдлыг бүрэн хангаж, хариуцагч албан хаагч аюулгүй байдлын заавар зөвлөгөө өгч, жолоочтой хариуцлагын гэрээ байгуулах. Гэрээний нэг хувийг Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газарт ирүүлэх.

Зохион байгуулагчидтай холбоо барих утас:

88822046, 80508748, 90300026

Аймгийн Задаг даргын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 1396 дугаар захирамжийн хөрөнгөөр хэвсрэлт



**“YOUTH POWER 2024” БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ
ЗАЛУУСЫН ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	2	3	4	5	6
1	Энгэрийн тэмдэг	Ширхэг	95	3000	285.000
2	Зочин илтгэгч, YSC-ын төлөөлөгч нарын оройн хоол /04.12/	Хүн	6	30.000	180.000
3	Зочин илтгэгч нарын замын зардал	Хүн/удаа	2/2	48.000	192.000
4	Зочин илтгэгч нарын байрлах буудал	Өрөө/хоног	1/2	179.000	358.000
5	Сумдаас ирэх оролцогчдын замын зардал	Хүн/удаа	60/2	20.000	2.400.000
6	Маркер	Хайрцаг	2	12.000	24.000
7	Тунхаг бичгийн цаас	Боодол	1	25.000	25.000
8	Ундаа, ус	Ширхэг	225	1500	337.500
9	Заалны түрээсийн зардал	Цаг	1 цаг	49.000	49.000
Нийт дүн			3.850.500 төгрөг		

_____оОо_____